



2018

ЖИЛИЙН ТАЙЛАН



ГАРЧИГ

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	1
Байгууллагын бүтэц, зохион байгуулалт	3
Оны онцлох үйл явдлууд	6
Хөрөнгийн зах зээлийн тойм	14
Үнэт цаасны бүртгэлд орсон өөрчлөлтүүд	18
Гишүүн компани	20
Хараат бус аудиторын тайлан	23
Санхүүгийн үзүүлэлтүүд	26
Мөнгөн гүйлгээний тайлан	28

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт та бүхэнд Монголын хөрөнгийн биржийн 2018 оны тайланг танилцуулж байгаадаа баяртай байна.

Өнгөрсөн 2018 он Монголын хөрөнгийн бирж болон хөрөнгийн зах зээлийн хувьд түүхэн чухал үйл явдлууд тохиосон, их өсөлт хөгжлийн жил байлаа. Тухайлбал, 2018 онд Канад улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” Монголын хөрөнгийн биржид бүртгүүлснээр Монголын хөрөнгийн зах зээлд анхны давхар бүртгэл хийгдэж, Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжил нэг алхмаар урагшиллаа. Мөн үүсгэн байгуулагдсанаас хойш 27-н жилийн түүхэндээ анх удаа хамгийн олон буюу 5 шинэ, 2 нэмэлт үнэт цаас, үүнд даатгалын салбарын анхны компаниуд бүртгэгдсэн, хувьцааны арилжааны дүн түүхэн дээд хэмжээнд хүрсэн зэрэг амжилт ололтоор дүүрэн байв.

Энэхүү үйл явдлууд нь Монгол Улсын хөрөнгийн зах зээл олон улсын жишгийн дагуу сонгодог зах зээлийн утгаараа ажиллаж эхэлснийг харуулж байгаа бөгөөд бид бүхэн зах зээлийн дэд бүтцийн байгууллагын хувьд энэхүү ололт амжилтуудаа баталгаажуулж, зах зээлийн хөгжлийг дэмжих үүднээс эрх зүйн орчныг сайжруулах, хөрөнгө оруулагчдын мэдлэгийг дээшлүүлэх, зах зээлийн ил тод байдлыг сайжруулах чиглэлээр шат дараалсан арга хэмжээнүүдийг авч ажиллалаа. Үүний хүрээнд, бид үйл ажиллагааны үндсэн дүрэм, журмуудаа шинэчилж, Биржийн цахим хуудсаар иргэдэд хүрэх мэдээллийн агуулга, цар хүрээ, нэр төрлийг олшруулснаас гадна нийт 9 аймагт “Үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөг” зохион байгуулж, хөрөнгө оруулагчдад арилжааны дадлага туршлага олгох зорилготой демо буюу хийсвэр арилжааны системийг нэвтрүүллээ.

Цаашид бид зах зээлд оролцох мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлж, зах зээлийн хөрвөх чадварыг хангах үүднээс хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн зохицуулалтын орчинг бий болгох, хөрөнгийн зах зээлийг гадаадын хөрөнгө оруулалтын урсгалыг татах томоохон суваг болгох, олон улсын жишигт нийцсэн төлбөр тооцооны T+2 горимыг эргэн нэвтрүүлэх чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай үргэлжлүүлэн хамтран ажиллах, бүртгэлтэй үнэт цаасны чанарыг сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулагч болон үнэт цаас гаргагчдад таатай дэд бүтэц, орчин, ил тод нээлттэй зах зээлийг бий болгохоор хичээн ажиллах болно.

Хөрөнгийн зах зээл цаашид улам хөгжин дэвшиж, хөгжлийн гарц байх болтугай.

Х.АЛТАЙ




ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2 дахь заалтын дагуу “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн дүрэмд Төлөөлөн удирдах зөвлөл нь 6 хараат, 3 хараат бус нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар тусгасан байдаг бөгөөд “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь компанийн хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлэгч Сангийн яам буюу Сангийн сайдын тушаалаар томилогддог.

ТУЗ-ийн дарга

1 М.Батхуяг Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга

Гишүүд

2 Б.Сүх-Очир Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга
3 Д.Баянзул Монголбанкны Эрсдэлийн удирдлагын албаны захирал
4 Л.Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга
5 М.Аясгалан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга
6 С.Ганзориг Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын мэргэжилтэн /2018 оны 10 сарын 01-ний өдөр хараат гишүүнээс чөлөөлсөн/

Хараат бус гишүүд

7 Р.Гандиймаа Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн “Монголын мэдээ” сувгийн захирал
8 А.Батпүрэв “Скайтел групп” ХХК-ийн Стратеги, удирдлагын газрын захирал
9 А.Анар “МИК ОССК” ХХК-ийн Үйл ажиллагааны газрын захирал

Аудитын хороо

№	Нэр	Үүрэг
1	А.Батпүрэв	Дарга
2	А.Анар	Гишүүн
3	С.Ганзориг	Гишүүн

Цалин, урамшууллын хороо

№	Нэр	Үүрэг
1	Б.Сүх-Очир	Дарга
2	Р.Гандиймаа	Гишүүн
3	А.Анар	Гишүүн

Нэр дэвшүүлэх хороо

№	Нэр	Үүрэг
1	Л.Сонор	Дарга
2	Р.Гандиймаа	Гишүүн
3	А.Батпүрэв	Гишүүн

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ЖУРМУУД ШИНЭЧЛЭГДЭН БАТЛАГДЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Үнэт цаасны индекс тооцох журам”-ын шинэчилсэн найруулга болон “Арилжааны журам”-ын нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдөр, “Гишүүнчлэлийн журам”-ын шинэчилсэн найруулгыг 2018 оны 7 дугаар сарын 18-ны өдөр, “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын шинэчилсэн найруулгыг 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Санхүүгийн зохицуулах хороо тус тус батламжилснаар зах зээлд мөрдөгдөж эхэллээ.

- Шинэчлэн найруулсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д үнэт цаасны давхар бүртгэлийн үйл ажиллагааны зохицуулалтыг нэвтрүүлж, үнэт цаас гаргагчдад, тэр дундаа уул уурхайн компаниудад тавигдах шалгуур, шаардлагыг шинээр тогтоосон. Мөн бүртгэлийн хураамжийн тооцооллыг зах зээлийн нийт үнэлгээнээс тооцох тухай болон компанийн сайн засаглалыг дэмжих үүднээс нэгдүгээр ангиллын компаниудын үнэт цаас бүртгүүлэх бүртгэлийн хураамж болон жилийн хураамжид хөнгөлөлт үзүүлэх, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн үйл ажиллагаатай компаниудын бүртгэлийн хураамжийг хөнгөлөх зэрэг зохицуулалтуудыг тусгасан.



- “Арилжааны журам”-д арилжааны хаалтын ханшийг сүүлийн нэг цагийн дунджаар тогтоох, багцын арилжааны ханш доод хязгаартай байх, дээд хязгааргүй байх, үнэт цаасны захиалгын бусдад харагдах тоо ширхгийг тогтоох функц, Бүхэлд нь даруй биелэгдэх эсвэл цуцлагдах захиалга /Fill or Kill/ болон “Минимумаас их дүнгээр биелэгдэх захиалга” /MinFill - худалдах, худалдан авах хамгийн бага тоо хэмжээг зааж өгөх бөгөөд заасан хэмжээнээс бага хэмжээгээр биелэгдэхгүй байх нөхцөлтэй захиалга/ зэрэг шинэ төрлийн захиалгын тодотголуудыг шинээр оруулах зэрэг нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан.
- “Үнэт цаасны үнийн индекс тооцох журам”-д индексийн тооцоололд компанийн олон нийтэд арилжих хувь хэмжээг оруулан тооцдог болсны зэрэгцээ MSE A болон B ангиллын индексийг шинээр нэвтрүүлэх, MSE All индекс тооцооллыг халах зэрэг томоохон өөрчлөлтүүдийг хийсэн.
- “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам” нь хөрөнгө оруулагчдаас захиалга хүлээн авах арга тус бүрийн онцлогийг харгалзан үнэ тогтоох, хуваарилалт хийх зарчмыг олон улсын нийтлэг жишигт нийцүүлсний зэрэгцээ бусад журмуудтай давхацсан зохицуулалтуудыг хасч, практик хэрэглээнд нийцүүлэх өөрчлөлтүүдийг оруулсан болно. Тухайлбал, тухайн нийтэд санал болгож буй үнэт цаасны 50 хүртэлх хувийг стратегийн хөрөнгө оруулагчид хуваарилах эрхийг андеррайтерт олгох, тогтоосон үнийн аргын үед харилцагчийн захиалгыг нэг үнийн түвшинд хүлээн авч, хуваарилалтыг зөвхөн хувь тэнцүүлэх аргаар хийж, жижиг хөрөнгө оруулагчдыг дэмжих, захиалгын бүртгэлийн аргын үед ханшийн дээд, доод хязгаарын хүрээнд захиалга авах, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээс хамаарч интервалыг шинэчилж тогтоож болох тухай зохицуулалтуудыг нэвтрүүлсэн.

Эдгээр шинэчлэгдсэн журмуудын хүрээнд гарах өөрчлөлтүүдийн талаар олон нийтэд мэдээлэх, сурталчлан таниулах зорилгоор зах зээлийн мэргэжлийн оролцогч нарт зориулсан танилцуулга, сургалт зохион байгууллаа.

ҮНЭТ ЦААСНЫ АНХНЫ ДАВХАР БҮРТГЭЛ НЭВТЭРЛЭЭ

Үнэт цаасны давхар бүртгэл буюу гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй компани, дотоодын биржид бүртгүүлж үнэт цаасаа арилжих, дотоодын биржид бүртгэлтэй компани нь гадаадын биржид бүртгүүлэх ажиллагааг нэвтрүүлэх хууль эрх зүйн орчин 2013 онд “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга батлагдсанаар бүрдсэн хэдий ч бүртгэлийн үйл ажиллагааг зохицуулах нарийвчилсан журам батлагдаагүй байснаас гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг компаниуд Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэн үнэт цаасаа арилжих боломжгүй байсан билээ.



Тус ажиллагааг зохицуулах нарийвчилсан журам болох “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-ыг Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн хамтарсан ажлын хэсэг боловсруулж, Хорооны 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар баталсан билээ. Хорооны энэхүү журамтай нийцүүлэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иас үнэт цаасны давхар бүртгэлийг зохицуулах зохицуулалтыг тусган “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг шинэчлэн боловсруулсан.

Уг журмын дагуу давхар бүртгэгдэж буй компанийг бүртгэлийн шалгуур, шаардлагаас хөнгөлөх, анх бүртгэгдсэн биржийн дүрэм журмыг мөрдөхийг зөвшөөрөх олон улсын нийтлэг зарчмын дагуу, дотоодын биржид үнэт цаас давхар бүртгүүлэх компаниуд нь анх бүртгэгдсэн биржийн болон үүсгэн байгуулагдсан улсын хууль тогтоомжийг мөрдөх, аудитын, хуулийн зэрэг мэргэжлийн дүгнэлтийг олон улсын компаниар гүйцэтгүүлснийг дотоодын компанийн дүгнэлттэй дүйцүүлэн хүлээн авах зэргээр төвөг чирэгдэл багатай байх зохицуулалтыг тусгасан юм.

Ийнхүү, үнэт цаасны давхар бүртгэлийн зохицуулалтын орчинг бүрдүүлсний үндсэнд Канад улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, Монгол улсад хайгуулын үйл ажиллагаа явуулдаг “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” (TSX:ERD) -ийн 1.2 сая канад долларын үнийн дүн бүхий 4 сая ширхэг энгийн хувьцааг 2018 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр үнэт цаасны бүртгэлийн 3-р ангилалд бүртгэж, үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 2018 оны 06 дугаар сарын 04-14-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулав. Тус арилжаанд нийт 1,248 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 6,478,146 ширхэг худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнг даруй 66 хувиар давсан үзүүлэлт болсон юм.

Монголын хөрөнгийн зах зээлд энэхүү цоо шинэ бүтээгдэхүүн нэвтэрсэн нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг, гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй 30 гаруй уул уурхайн компаниуд Монгол улсад үнэт цаасаа гарган арилжих, эдгээр компанийн хувьцааг ард иргэд, олон нийт эзэмшиж, байгалийн баялгийн үр шимийг хүртэх боломжийг нэмэгдүүлсний зэрэгцээ Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг нэгэн шатаар ахиулж, дэлхий нийтийн жишиг хандлагын дагуу хөгжүүлэхэд түүхэн чухал ач холбогдолтой үйл явдал боллоо.

ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

“ЛЕНДМН ББСБ” ХК ҮНЭТ ЦААС ГАРГАЛАА

“Лендмн ББСБ” ХК нь нийт хувьцааны 25%-ийг буюу 200 сая ширхэг хувьцааг олон нийтэд болон стратегийн хөрөнгө оруулагч нарт санал болгож, хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс 03 дугаар сарын 07-ны өдрийн хооронд амжилттай зохион байгууллаа.



“Лендмн ББСБ” ХК-ийн олон нийтэд санал болгосон 12.5 хувь буюу 100 сая ширхэг хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад 6,551 хувь хүн, аж ахуйн нэгжүүд оролцож, нийтдээ 1,659,715,218 ширхэг үнэт цаасны худалдан авах захиалга өгсөн нь олон нийтэд санал болгосон 100 сая ширхэг хувьцааг 16.5 дахин давж, Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд хамгийн их худалдан авах захиалга авсан амжилт тогтоолоо.

чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Райнос Ассет оролцсоноороо онцлогтой юм.

Түүнчлэн, тус компанийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд БНСУ-д хөрөнгө оруулалтын менежментийн Менежмент компани стратегийн хөрөнгө оруулагчаар

ДААТГАЛЫН САЛБАРЫН КОМПАНИУД АНХ УДАА ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛЭЭС ХӨРӨНГӨ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭЭ



Монголын даатгалын салбараас анх удаа “Мандал даатгал” ХК болон “Ард даатгал” ХК Монголын хөрөнгийн биржид үнэт цаасаа бүртгүүллээ. “Мандал Даатгал” ХК нь нийт хувьцааныхаа 25% буюу 1,560,754 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 4800 төгрөгөөр олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлд 2018 оны 9 дүгээр сарын 04-18-ны өдрүүдэд амжилттай худалдаж 7,49 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн бөгөөд тус арилжаанд нийт 861 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 1,916,207 ширхэг хувьцаа худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнг 23 хувиар давсан үзүүлэлт болов.

“Ард даатгал” ХК нь нийт хувьцааныхаа 30 хувь буюу 7,500,000 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 700 төгрөгөөр олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлд 2018 оны 9 дүгээр сарын 17-26-ны өдрүүдэд амжилттай худалдаж нийт 5.25 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн бөгөөд тус арилжаанд нийт 1,367 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 9,954,848 ширхэг хувьцаа худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнгээс 32.7 хувиар давсан үзүүлэлт болов.



ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

Ийнхүү, даатгалын салбарын компаниуд Монголын хөрөнгийн биржид бүртгүүлж, олон нийтээс амжилттай хөрөнгө татан төвлөрүүлсэн нь Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлж, олон нийтийн компани болох боломж нээлттэй байгааг бусад даатгалын компаниудад харуулж байгаагийн зэрэгцээ хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлж, зах зээлийн хөгжлийг нэг алхмаар урагшлуулах чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм.

“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК ҮНЭТ ЦААС ГАРГАЛАА



“Монгол Базалыт” ХК нь нийт хувьцааныхаа 30% буюу 16,925,100 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлд 2018 оны 05 дугаар сарын 14-23-ны өдрүүдэд амжилттай худалдаж нийт 6.4 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлэв. Тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд нийт 3,086 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 53,562,855 ширхэг худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнг даруй 3.1 дахин давсан үзүүлэлт боллоо.

“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАЛАА



“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2-р ангилалд бүртгэлтэй “Хөвсгөл Алтандуулга” ХК нийт 4.4 сая ширхэг буюу нийт хувьцааныхаа 28%-тай тэнцэх хувьцааг нэмж гаргах замаар 3,74 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр олон нийтийн захиалгыг 2018 оны 8 дугаар сарын 08-16-ны өдрүүдэд, стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг СЗХ-ноос өгсөн чиглэлийн дагуу 2018 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр тус тус хүлээн авснаар анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдав. “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжаанд нийт 100 иргэн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 4,405,600 ширхэг үнэт цаасны худалдан авах захиалга өгсөн байна.

“ЦЕМЕНТ ШОХОЙ” ХК ХААЛТТАЙ ХҮРЭЭНД НЭМЭЛТ ҮНЭТ ЦААС ГАРГАЛАА

МХБ-ийн үнэт цаасны 3-р ангилалд бүртгэлтэй “Цемент Шохой” ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 6 сая ширхэг энгийн хувьцааг хаалттай хүрээнд санал болгон гаргахыг СЗХ-ны 2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 316 тоот тогтоолоор зөвшөөрсний дагуу тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр явагдаж, нэмж гаргаж буй үнэт цаасыг нэг бүрийг нь 170 төгрөгөөр амжилттай арилжлаа.

ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААСНЫ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАН АЖИЛЛАЛАА

МХБ нь бүртгэлтэй хувьцаат компаниудын хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийг сайжруулж, арилжигдаж буй бүтээгдэхүүний чанарыг сайжруулах чиглэлээр ажлын төлөвлөгөө батлан ажиллалаа. Үүний хүрээнд, МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон Бүртгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлдэггүй, зохих шалгуур, шаардлагыг хангахгүй байгаа, арилжаа зогссон компаниудын талаар олон нийтэд мэдээлж, зөрчлөө арилгах талаар хугацаатай үүрэг даалгавар өгч, зарим компаниудын үнэт цаасыг бүртгэлээс хасах хүртэл арга хэмжээ авлаа. Тухайлбал, МХБ-д бүртгэлтэй “Дархан мах экспо” ХК, “Эвлэл” ХК, “Ажлын хувцас” ХК, “АЗЗАН” ХК, “Бэрэн майнинг” ХК зэрэг 5 компанийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/139 тоот тушаалаар бүртгэлтэй хувьцаат компанийн жагсаалтаас хасав.

ГУРВАН КОМПАНИ ГИШҮҮНЭЭР ЭЛСЭЖ, ХОЁР ГИШҮҮН ҮЦК-ИЙН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЭРХ ЦУЦЛАГДЛАА

Монгол Улсын Компанийн тухай хууль болон СЗХ, МХБ-ийн холбогдох дүрэм, журамд үндэслэн гаргасан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2018/17 тоот тогтоолоор “Би Би Эс Эс ҮЦК” ХХК, “Говийн ноён нуруу ҮЦК” ХХК-иудын биржийн гишүүнчлэлийн эрхийг цуцалж, гишүүнээс хаслаа. Тус компаниудын харилцагчдыг СЗХ-ны 2018 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 127 тоот тогтоолын дагуу “Бумбат Алтай ҮЦК” ХХК-д шилжүүлсэн тул гишүүнээс хасагдсан дээрх компаниудын харилцагчид нэмэлт төлбөр, зардал чирэгдэлгүйгээр үнэт цаасны дансаа үргэлжлүүлэн эзэмшиж, үнэт цаасны арилжаанд саадгүй оролцох боломжтой юм.

Түүнчлэн, тайлант онд “Инвескор капитал ҮЦК” ХХК, “Централ секюритиз ҮЦК” ХХК, “Силвер лайт секюритиз ҮЦК” ХХК МХБ-д гишүүнээр элссэнээр гишүүн компаниудын тоо 59-д хүрлээ.

ИХ БРИТАНИЙН АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙГ ХАРИУЦСАН САЙД МАРК ФИЙЛД МХБ-Д ЗОЧИЛОО



Их Британийн Гадаад Харилцааны Яамны Ази Номхон Далайн Бүс Нутгийг хариуцсан сайд Марк Фийлд 2018 оны 7-р сарын 19-22-ны өдрүүдэд Монгол улсад хийж байгаа айлчлалынхаа хүрээнд 2018 оны 7-р сарын 20-ны өдөр Монголын хөрөнгийн биржид зочиллоо. Сайд Марк Фийлдэд МХБ-ийн үйл ажиллагаа, цаашдын зорилгыг танилцуулсан бөгөөд манай улсын хөрөнгийн зах зээл хөгжил дэвшил, үйл явдлаар өрнүүн байгааг сайд онцлон тэмдэглэлээ. Монголын хөрөнгийн зах зээлийг цаашид хөгжүүлэх ажил, олон шинэ санаачлагуудад Их Британийн талаас дэмжин хамтран ажиллах бөгөөд өдгөө долоо дахь жилдээ үргэлжилж буй МХБ болон Лондонгийн хөрөнгийн биржийн стратеги хамтын ажиллагаа нь улам өргөжин тэлнэ гэдэгт итгэлтэй

байгаагаа илэрхийлж, МХБ-ийн хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурав.

ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

ДЕМО АРИЛЖААНЫ СИСТЕМИЙГ ШИНЭЭР НЭВТРҮҮЛЛЭЭ

МХБ нь иргэдийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хөрөнгийн зах зээлд оролцох иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор демо буюу хийсвэр арилжааны системийг нэвтрүүлж, ашиглалтанд орууллаа. Демо буюу хийсвэр арилжааны систем нь бодит мөнгөөр арилжаанд оролцож эхлэхээс өмнө хийсвэр мөнгөөр арилжаанд орж, үнэт цаасны арилжаанд оролцох дадлага хийх, хөрөнгөө өсгөх арга барилаа олоход туслах ач холбогдолтой систем юм. Иргэд энэхүү системийг ашиглан өөрийн демо дансыг хүссэн дүнгээрээ цэнэглэж, МХБ-д бүртгэлтэй хувьцаануудаас сонгон тухайн өдрийн арилжааны бодит ханшаар худалдан авах эсвэл эргүүлэн худалдаж, холбогдон гарах брокерийн шимтгэлийг төлөх зэргээр МХБ дээр явагддаг бодит арилжааны туршлагыг олж авахаас гадна тус системийн “Дансны шинжилгээ” функц нь хөрөнгө оруулагчийн арилжааны ашиг, алдагдлыг өдөр бүр тооцоолж харуулдаг ач холбогдолтой.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГИЙГ 9 АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



МХБ нь орон нутгийн иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, үнэт цаасны компаниуд болон “Эрдэнэс таван толгой” ХК-тай хамтран Дархан-Уул, Булган, Орхон, Увс, Баян-Өлгий, Ховд, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгуудад “Үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөг” арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр хөрөнгийн зах зээлийн суурь ойлголтууд, хувьцаа, бондын арилжаанд хэрхэн оролцох, хөрөнгийн зах зээлээс компаниуд санхүүжилт татах боломж зэрэг сэдвээр сургалт явуулснаас гадна “Эрдэнэс таван толгой” ХК-ийн үйл ажиллагаа, иргэдэд олгосон хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, өмч хувьчлалын үед олгогдсон хөрөнгө оруулалтын эрхийн бичигтэй /ягаан цэнхэр тасалбар/ холбоотой дансны мэдээллийг шүүх, ногдол ашгийн мэдээллийг өгөх, үнэт цаасны данс нээх, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зэргээр нийт 10,000 гаруй иргэдэд нэг цэгийн цогц үйлчилгээг үзүүллээ.



БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИУД 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА НЭЭЛТТЭЙ ТАНИЛЦУУЛЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь бүртгэлтэй хувьцаат компаниудын мэдээллийн ил тод, нээлттэй байдал, үүргийн хэрэгжилт, компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг хангуулах зорилгоор МХБ-ийн бүртгэлтэй компаниудын хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг олон нийтэд нээлттэй илтгэл хэлбэрээр танилцуулах ажлыг 2018 оны 8 дугаар сарын 08-16-ны өдрүүдэд 3 дахь жилдээ уламжлал болгон зохион байгууллаа.

ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

Тус арга хэмжээнд 1-р ангилалд бүртгэлтэй “Сүү” ХК, “Таван толгой” ХК, “Мик Холдинг” ХК, “Говь” ХК, “Дархан нэхий” ХК, “АПУ” ХК, “Монгол шуудан” ХК, 2-р ангилалд бүртгэлтэй “Монгол Базальт” ХК, “Айтүүлс” ХК зэрэг компаниуд оролцож, олон нийтэд үйл ажиллагаагаа танилцууллаа.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ЦАХИМ ХУУДАС ШИНЭЧЛЭГДЛЭЭ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь өөрийн цахим хуудасны бүтэц, зохион байгуулалт, агуулгыг сайжруулан шинэчилж ашиглалтад орууллаа. Энэхүү шинэчлэгдсэн хувилбараар хөрөнгө оруулагчид бүртгэлтэй хувьцаат компаниудын мэдээллийг нүүр хуудсаар дамжуулан цаг алдалгүй, хялбар аргаар авах боломжтойгоос гадна “Таны мэдлэгт” булангаас хөрөнгийн зах зээлийн үндсэн ойлголт, арилжаанд хэрхэн оролцох тухай танилцуулга, хийсвэр арилжааны платформ болон хөрөнгийн зах зээлийн мэдлэг олгох бусад мэдээлэл, материалуудтай танилцах боломжтой юм. Түүнчлэн, “Үнэт цаас бүртгүүлэх” цэснээс хөрөнгийн зах зээлд хувьцаа, бонд гаргах сонирхолтой компаниуд хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох тухай мэдээ мэдээллийг нэг дороос авах боломж бүрдлээ.

БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИУДЫН АНГЛИ ХЭЛ ДЭЭРХ МЭДЭЭЛЛИЙН ЦАР ХҮРЭЭГ НЭМЭГДҮҮЛЛЭЭ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь үнэт цаасны зах зээлд оролцогч олон улсын хөрөнгө оруулагчдад тэнцвэртэй мэдээлэл хүргэх зорилгоор өөрийн цахим хуудсаар дамжуулан зах зээлийн үйл явдлын болон өдөр тутмын арилжааны мэдээ, мэдээллийг Англи хэл дээр тогтмол бэлтгэн хүргэхээс гадна олон улсын санхүүгийн мэдээ, мэдээллийн Блүүмберг болон бусад терминалуудаар дамжуулан арилжааны мэдээлэл, компаниудын санхүүгийн тайлан, шийдвэр, шинэ үнэт цаасны мэдээлэл зэргийг олон улсын хөрөнгө оруулагчдад хүргэдэг билээ. 2018 онд МХБ-д бүртгэлтэй компаниудын санхүүгийн тайлан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг Англи хэл дээр хөрвүүлж, нийтлэх ажлыг анх удаа хийж гүйцэтгэлээ.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Үнэт цаасны арилжаа

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 252 удаагийн арилжаагаар 136 компанийн 666.8 сая ширхэг хувьцааг 210 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 332.8 мянган ширхэг үнэт цаасыг 33.5 тэрбум төгрөгөөр, компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 6.3 мянган ширхэг бондыг 631.6 сая төгрөгөөр тус тус арилжиж, нийт 244.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Нийт гүйлгээний үнийн дүнгийн 86.02%-ийг хувьцааны арилжаа, 13.72%-ийг ЗГҮЦ-ны арилжаа, 0.25%-ийг компанийн бондын арилжаа тус тус эзэлж байна.

Үнэт цаасны арилжаа /2018.12.31-ний өдрийн байдлаар/

Үнэт цаасны төрөл		Арилжаалагдсан тоо /сая ширхэг/	Арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/
Хувьцаа	Анхдагч зах зээл	240.3	31.4
	Хоёрдогч зах зээл	426.5	178.6
ЗГҮЦ	Хоёрдогч зах зээл	0.33	33.5
Компанийн бонд	Хоёрдогч зах зээл	0.01	0.6
Нийт		667.2	244.1

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 968.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий гүйлгээ хийгдэж, 2.6 сая ширхэг үнэт цаас арилжигдсан байна.


Арилжаалсан үнэт цаасны үнийн дүн /сүүлийн 4 жилд/

Үнэт цаасны нэр	2015 он	2016 он	2017 он	2018 он
Хувьцаа /тэрбум төг/	30.5	49.0	76.4	210
ЗГҮЦ /тэрбум төг/	515.5	299.6	772.5	33.5
Компанийн бонд /тэрбум төг/	0.5	-	10.2	0.63

Хувьцааны арилжаа

Тайлант онд нийт 252 удаагийн арилжаагаар 136 компанийн 666.8 сая ширхэг хувьцааг 210 тэрбум төгрөгөөр арилжаалсан. Хувьцааны арилжааны 60.6% буюу 127.4 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, 15% буюу 31.4 тэрбум төгрөгийн гүйлгээг анхдагч зах зээлийн арилжаа, 24.3% буюу 51.2 тэрбум төгрөгийг энгийн арилжаа тус тус эзэлж байна.

Хувьцааны арилжаа /үнийн дүнгээр/



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Багцын арилжаа

Тайлант онд багцын арилжаагаар АПУ, Мик холдинг, Лэндмн, Дархан Нэхий, Монголын Цахилгаан Холбоо зэрэг нийт 5 компанийн 161.2 сая ширхэг хувьцааг 127.4 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 60.6%-ийг эзэлж байна.

Тендер саналын арилжаа

Монгол Улсын Засгийн Газар нь “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн хувьцааны хяналтын багцыг дангаараа эзэмшигч болсон тул “Компанийн тухай” хуулийн 57.1, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 22.1.2 болон СЗХ-ны “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам”-ыг үндэслэн үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн үнэт цаасыг худалдаж авах санал гаргасан бөгөөд тус арилжаагаар 7572 ширхэг хувьцааг 4.1 сая төгрөгөөр арилжсан байна.

Анхдагч зах зээлийн арилжаа

2018 оны 3 дугаар сард “Лэндмн ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан 200 сая ширхэг хувьцааг 5 тэрбум төгрөгөөр, 5 дугаар сард “Монгол Базальт” ХК-ийн 16.9 сая ширхэг хувьцааг 6.4 тэрбум төгрөгөөр, 6 дугаар сард “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК-ийн 3.8 сая ширхэг хувьцааг 2.4 тэрбум төгрөгөөр, 9 дүгээр сард “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн нэмж гаргаж буй 4.4 сая ширхэг хувьцааг 3.7 тэрбум төгрөгөөр, “Мандал даатгал” ХК-ийн 1.5 сая ширхэг хувьцааг 7.5 тэрбум төгрөгөөр, “Ард даатгал” ХК-ийн 7.5 сая ширхэг хувьцааг 5.2 тэрбум төгрөгөөр, “Цемент шохой” ХК-ийн хаалттай хүрээнд нэмж гаргасан 6 сая ширхэг хувьцааг 1 тэрбум төгрөгөөр анхдагч зах зээлд тус тус амжилттай арилжсан байна. Шинэ үнэт цаасны олон нийтэд санал болгосон хэмжээ ба олон нийтээс ирүүлсэн захиалгын хэмжээг доорх зурагт харуулав.



ЗГҮЦ-ны арилжаа

Тайлант хугацаанд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй бөгөөд хоёрдогч зах зээлд нийт 332.9 мянган ширхэг үнэт цаас 33.5 тэрбум төгрөгөөр арилжигдсан байна

Компанийн бондын арилжаа


2017 оны 06 дугаар сард “Сүү” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан өрийн хэрэгсэл 2018 оны 06 дугаар сард эргэн төлөлт хийгдсэн бөгөөд 2018 онд хоёрдогч зах зээлийн арилжаагаар 6316 ширхэг бондыг 631.6 сая төгрөгөөр арилжсан байна.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Зах зээлийн индикаторууд

Үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлдог гол индикатор болох Зах зээлийн үнэлгээ, Топ-20 индекс, мөн 2018 онд нэвтрүүлсэн MSE A, MSE B индексүүдийг 12 дугаар сарын 31-ий байдлаар харуулав.

Зах зээлийн үнэлгээ



2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар МХБ-д бүртгэлтэй олон нийтэд хувьцаа нь арилжигдаж буй компаниудын нийт зах зээлийн үнэлгээ нь 2 их наяд 508 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 71.7 тэрбум төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ.

ТОП-20 индекс

МХБ нь 1995 оноос ТОП 20 индексийг тооцож эхэлсэн бөгөөд индексийн сагсыг жилд нэг удаа шинэчилдэг. Өнгөрсөн оны үзүүлэлтээр сагсыг шинэчлэхэд өмнөх сагсад багтаж байсан 18 компани хэвээр үлдэж, “Багануур” ХК, “Женко Тур Бюро” ХК-иуд хасагдаж, шинээр “МИК Холдинг” ХК, “Шивээ Овоо” ХК-иуд нэмэгдэв. Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 21737.68 нэгж, доод үзүүлэлт 18861.36 нэгж, дундаж үзүүлэлт 20157.00 нэгж байв. ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 729.8 нэгжээр буюу 3.52 хувиар өсч, 21.466.76 нэгж болсон байна.



MSE A, B индекс

МХБ нь 2018 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн үнэт цаасны бүртгэлийн I, II ангиллын компаниудын ханшийн хөдөлгөөнийг харуулах MSE A, B индексийг албан ёсоор тооцож эхлээд байгаа билээ. Тайлант хугацаанд MSE A индексийн дээд үзүүлэлт нь 11091.79 нэгж, доод үзүүлэлт нь 8872.87 нэгж, дундаж үзүүлэлт нь 9661.84 нэгж, MSE B индексийн хувьд дээд үзүүлэлт нь 10202.94 нэгж, доод үзүүлэлт нь 8284.32 нэгж, дундаж үзүүлэлт нь 9388.79 нэгж тус тус байна.



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018 онд идэвхтэй арилжигдсан 20 үнэт цаас

Дараах 20 үнэт цаасны арилжигдсан тоо ширхэг нь нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхгийн 97 хувь, үнийн дүнгийн 98.43 хувийг тус тус эзэлж байна.

Үнэт цаас	Ширхэг	Эрэмбэ	Үнэт цаас	Үнийн дүн
ЛЭНДМН ББСБ	167,597,032	1	АПУ	92,375,598,444
АПУ	130,065,842	2	МИК ХОЛДИНГ	31,382,026,400
ХАЙ БИ ОЙЛ	28,825,477	3	ЛЭНДМН ББСБ	8,773,801,485
АЙТҮҮЛС	12,225,369	4	МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	6,579,732,233
ЖЕНКО ТУР БЮРО	11,822,843	5	ТАВАН ТОЛГОЙ	4,403,533,030
МОНГОЛ БАЗАЛЫТ	8,841,509	6	ГОВЬ	4,316,320,014
НАКО ТҮЛШ	7,592,699	7	ДАРХАН НЭХИЙ	4,052,753,180
ХӨХ ГАН	6,278,456	8	МОНГОЛ БАЗАЛЫТ	3,389,968,415
МОНИНЖБАР	5,725,986	9	АРД ДААТГАЛ	2,551,035,583
Э- ТРАНС ЛОЖИСТИКС	5,275,007	10	БИДИСЕК	2,354,260,408
РЕМИКОН	5,011,024	11	МАНДАЛ ДААТГАЛ	1,945,722,998
АРД ДААТГАЛ	3,254,589	12	ЖИНСТ УВС	1,520,513,182
СҮҮ	2,648,674	13	АЙТҮҮЛС	1,471,697,621
МЕРЕКС	2,343,489	14	ХАЙ БИ ОЙЛ	1,384,518,928
БИДИСЕК	2,327,568	15	ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА	1,157,668,997
МИК ХОЛДИНГ	2,010,049	16	МАХИМПЕКС	1,119,914,772
ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	1,948,272	17	ШИВЭЭ ОВОО	981,828,134
ГОВЬ	1,886,955	18	МОНИНЖБАР	959,459,406
МОНГОЛ ШУУДАН	1,375,011	19	ЖЕНКО ТУР БЮРО	834,756,765
ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА	1,317,242	20	НАКО ТҮЛШ	833,005,630
НИЙТ	409,689,974			173,216,446,440
НИЙТЭД ЭЗЛЭХ ХУВЬ	97.00%			98.43%

ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Хувьцааны бүртгэл

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 217 ХК бүртгэлтэй байгаагаас 8.3 % буюу 18 ХК нь 100 хувь төрийн өмчит, 4.6% буюу 10 ХК нь төрийн өмчийн оролцоотой, 87.1% буюу 189 ХК нь бүрэн хувьчлагдсан компани байна. Харин бүртгэлтэй үнэт цаасны хувьд нийт 11,4 тэрбум ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагаас 34.98% буюу 3.9 тэрбум ширхэг нь төрийн мэдлийн, 65.02% буюу 7.4 тэрбум ширхэг нь хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувьцаа байна.

Шинээр бүртгэгдсэн компаниуд

2018 онд МХБ-д шинээр үнэт цаас бүртгүүлэхээр 9 компани хүсэлтээ ирүүлснийг судалж, нийт 6 компанийн 840,660,016 ширхэг үнэт цаасыг шинээр бүртгэв.

№	Компанийн нэр	Бүртгэгдсэн хувьцааны тоо	МХБ-д бүртгэгдсэн огноо	Татан төвлөрүүлсэн хөрөнгө		
				Хувьцааны тоо	Нийт үнийн дүн	Ангилал
1	“Лэндмн ББСБ” ХК	800,000,000	2018-01-26	200,000,000	5,000,000,000	I
2	“Монгол базальт” ХК	5,417,000	2018-04-05	16,925,100	6,431,538,000	II
3	“Мандал даатгал” ХК”	6,243,016	2018-05-07	1,560,754	7,491,619,000	I
4	“Ард даатгал” ХК	25,000,000	2018-06-13	7,500,000	5,250,000,000	I
5	“Түмэн шувуут” ХК	200,000,000	2018-08-16	50,000,000	10,000,000,000	II
Давхар бүртгэл						
6	“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн”	4,000,000	2018-04-04	3,898,000	2,494,720,000	III

Нэмэлт хувьцаа гаргасан компаниуд

№	Компанийн нэр	Нэмж гаргасан үнэт цаасны тоо	МХБ-д бүртгэгдсэн огноо
1	“Хөвсгөл алтандуулга” ХК	4,405,600	2018-05-23
2	“Хөтөлийн цемент шохой” ХК	6,000,000	2018-07-20

Бүртгэлээс хасагдсан компаниуд

№	Компанийн нэр	Хувьцааны тоо ширхэг	Хасагдсан огноо	Үндэслэл
1	“Монгол шир” ХК	275,360	2018-02-13	Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн дагуу ХХК болсон
2	“Усжуулах” ХК	489,262	2018-11-16	Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн дагуу ХХК болсон
3	“АЗЗАН” ХК	10,956,664	2018-12-19	СЗХ-ны үнэт цаасны бүртгэлд бүртгэлгүй
4	“Дархан мах-экспо” ХК	1,075,692	2018-12-19	Татан буугдсан
5	“Ажлын хувцас” ХК	240,989	2018-12-19	Татан буугдсан
6	“Бэрэн майнинг” ХК	1,740,813,320	2018-12-19	Бүртгэгдсэнээс хойш 6 сарын дотор ҮЦ-ыг анхдагч зах зээлд гаргаагүй
7	“Эвлэл” ХК	43,798	2018-12-19	Татан буугдсан

ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсон компаниуд

№	Компанийн нэр	Шийдвэрийн огноо	Үнэт цаасны бүртгэлийн өөрчлөлт
1	“Говь” ХК	2018-11-30	Нэгж хувьцааг 100 хуваасан
2	“Баян Алдар” ХК	2018-06-26	“Монгорүматриксгинко ББСБ” ХК-тай нэгдсэн

Тайлант хугацаанд Сангийн яамнаас дотоодын үнэт цаасны зах зээлд Засгийн газрын үнэт цаас гаргахгүй байх төсөв, санхүүгийн бодлогыг баримталсантай холбоотой МХБ-д шинээр нэмж ЗГҮЦ бүртгэгдээгүй. Улмаар нийт 319 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдэж 3,515,114 ширхэг ЗГҮЦ-ыг бүртгэлээс хасав.

Бүртгэлтэй үнэт цаасны тоон мэдээлэл

ҮЗҮҮЛЭЛТ	2017.12.31	2018.12.31	ӨӨРЧЛӨЛТ
Бүртгэлтэй компанийн тоо	218	217	(1)
Үүнээс : Төрийн өмчит	31	29	(2)
Хувийн өмчийн	187	188	1
Бүртгэлтэй үнэт цаасны тоо /ширхэг/	11,232,171,351	11,396,054,507	163,883,156
Үүнээс : Төрийн өмчид /ширхэг/	3,975,394,457	3,986,710,485	11,316,028
Олон нийтэд /ширхэг/	7,256,776,894	7,409,344,022	152,567,128
Үнэт цаас шинээр бүртгүүлсэн ХК	2	6	4
Үүнээс: Төрийн өмчит ХК	-	-	0
Хувийн өмчийн	2	6	4
Шинээр бүртгүүлсэн үнэт цаасны тоо /ширхэг/	153,904,814	1,091,660,016	937,755,202
Нэмж үнэт цаас гаргасан ХК	3	3	0
Нэмж бүртгүүлсэн үнэт цаасны тоо /ширхэг/	3,074,305,471	22,871,536	(3,051,433,935)
Үнэт цаасны тоо ширхэгт өөрчлөлт орсон бусад ХК	1	3	2
Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсноор нэмж бүртгэгдсэн үнэт цаасны тоо ширхэг	5,153,544	803,246,689	798,093,145
Бүртгэлээс хасагдсан ХК	11	7	(4)
Хасагдсан үнэт цаасны тоо /ширхэг/	2,235,878	1,753,895,085	(1,751,659,207)

№	Компанийн нэр	Үйл ажиллагааны чиглэл			2018 онд хийсэн арилжааны дүн	
		Брокер, дилер	Андеррайтер	Хөрөнгө оруулалтын зөвлөх	Арилжааны дүн	Арилжаанд эзлэх хувь
1	“ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК” ХХК	•	•	•	194,959,607,638	39.9%
2	“ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК” ХХК	•	•		71,583,559,504	14.7%
3	“МИРЭ ЭССЭТ СЕКЬЮРИТИС МОНГОЛ ҮЦК” ХХК	•	•	•	58,233,086,525	11.9%
4	“БИ ДИ СЕК ҮЦК” ХХК	•	•	•	39,510,233,868	8.1%
5	“НОВЕЛ ИНВЕСТМЕНТ ҮЦК” ХХК	•		•	28,210,906,685	5.8%
6	“БУМБАТ-АЛТАЙ ҮЦК” ХХК	•	•	•	24,578,030,928	5.0%
7	“ГАУЛИ ҮЦК” ХХК	•	•		18,952,097,539	3.9%
8	“АРД СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХХК	•	•	•	11,039,788,339	2.3%
9	“СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК” ХХК	•	•	•	9,131,544,218	1.9%
10	“АРД КАПИТАЛ ГРУПП ҮЦК” ХХК	•	•		8,402,342,082	1.7%
11	“ДЭЛГЭРХАНГАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХХК	•			7,886,624,099	1.6%
12	“АПЕКС КАПИТАЛ ҮЦК” ХХК	•			1,892,634,318	0.4%
13	“МОНСЕК ҮЦК” ХХК	•	•		1,623,980,206	0.3%
14	“БЛҮМСБЮРИ СЕКЬЮРИТИЕС ҮЦК” ХХК	•	•		1,431,965,028	0.3%
15	“САНАР ҮЦК” ХХК	•			1,026,308,995	0.2%
16	“БАТС ҮЦК” ХХК	•			1,015,499,589	0.2%
17	“ГЕНДЕКС ҮЦК” ХХК	•			879,114,025	0.2%
18	“ТУЛГАТ ЧАНДМАНЬ БАЯН ҮЦК” ХХК	•			793,885,097	0.2%
19	“ЗЭРГЭД ҮЦК” ХХК	•			761,260,270	0.2%
20	“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХХК	•	•	•	660,441,910	0.1%
21	“ГҮҮДСЕК ҮЦК” ХХК	•	•	•	640,455,424	0.1%
22	“ЛАЙФТАЙМ ИНВЕСТМЕНТ ҮЦК” ХХК	•	•		549,277,614	0.1%
23	“ХҮННҮ ЭМПАЙР ҮЦК” ХХК	•			538,754,964	0.1%
24	“ТАВАН БОГД ҮЦК” ХХК	•			407,160,525	0.1%
25	“ДАРХАН БРОКЕР ҮЦК” ХХК	•			399,628,032	0.1%
26	“ТЭНГЭР КАПИТАЛ ҮЦК” ХХК	•	•	•	396,198,391	0.1%
27	“ГРАНДДЕВЕЛОПМЕНТ ҮЦК” ХХК	•			375,267,764	0.1%
28	“ЭМ АЙ БИ ЖИ ХХК ҮЦК”	•	•		322,063,681	0.1%
29	“МЭРГЭН САНАА ҮЦК” ХХК	•			277,908,203	0.1%
30	“БУЛГАН БРОКЕР ҮЦК” ХХК	•			231,014,466	0.0%

31	“ӨНДӨРХААН ИНВЕСТ ҮЦК” ХХК	•			226,430,913	0.0%
32	“НЭЙШНЛ СЕКЬЮРИТИС ҮЦК” ХХК	•	•	•	180,965,808	0.0%
33	“МОНГОЛ СЕКЬЮРИТИЕС ҮЦК” ХК	•			176,331,062	0.0%
34	“МАСДАК ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИ” ХХК	•			158,827,008	0.0%
35	“АЛТАН ХОРОМСОГ ҮЦК” ХХК	•			153,686,299	0.0%
36	“БЛЭКСТОУН ИНТЕРНЭЙШНЛ ҮЦК” ХХК	•			133,224,204	0.0%
37	“АЗИА ПАСИФИК СЕКЬЮРИТИС ҮЦК” ХХК	•			131,223,044	0.0%
38	“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК	•			87,975,976	0.0%
39	“ЭМ АЙ СИ СИ ҮЦК” ХХК	•	•		73,291,460	0.0%
40	“СИКАП ҮЦК” ХХК	•	•		66,465,357	0.0%
41	“СИЛВЭР ЛАЙТ СЕКЬЮРИТИЙЗ ҮЦК” ХХК	•			56,075,673	0.0%
42	“ГАЦУУРТ ТРЕЙД ҮЦК” ХХК	•			48,181,245	0.0%
43	“ЗЭТ ЖИ БИ ҮЦК” ХХК	•			22,435,840	0.0%
44	“ЦЕНТРАЛ СЕКЬЮРИТИЙЗ ҮЦК” ХХК	•			21,660,331	0.0%
45	“АРГАЙ БЭСТ ҮЦК” ХХК	•			20,811,836	0.0%
46	“ЭФ СИ ИКС ҮЦК” ХХК	•	•		3,788,300	0.0%
47	“ДИ СИ ЭФ ҮЦК” ХХК	•			49,000	0.0%
48	“КАПИТАЛ МАРКЕТ КОРПОРАЦИ ҮЦК” ХХК	•	•		-	0.0%
49	“АСЕ ЭНД Т КАПИТАЛ ҮЦК” ХХК	•	•	•	-	0.0%
50	“ЭС ЖИ КАПИТАЛ ҮЦК” ХХК	•	•	•	-	0.0%
51	“ФРОНТИЕР ҮЦК” ХХК	•			-	0.0%
52	“ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК” ХХК	•	•	•	-	0.0%
	Нийт	55	24	14	488,272,063,284	0.0%

СЗХ-ноос үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан боловч Монголын хөрөнгийн биржийн гишүүнчлэлийн эрх нь цуцлагдаагүй, холбогдох шалгалтын ажил явагдаж буй дараах нэр бүхий 7 компани байна. Тус компаниудын харилцагчдыг СЗХ-ны шийдвэрээр нэр заасан компаниуд руу шилжүүлснээр харилцагч нэмэлт төлбөр төлөлгүйгээр өөрийн дансаараа арилжаанд оролцох боломжтой юм

№	Тусгай зөвшөөрөл цуцлагдсан ҮЦК-ийн нэр	Харилцагч шилжүүлэн авсан ҮЦК
1	“Бага хээр ҮЦК” ХХК	“Өндөрхаан инвест ҮЦК” ХХК
2	“Догсон ҮЦК” ХХК	Тендер зарлагдаагүй
3	“Финанс линк групп ҮЦК” ХХК	“Бумбат-Алтай ҮЦК” ХХК
4	“Ай трейд ҮЦК” ХХК	“Бумбат-Алтай ҮЦК” ХХК
5	“Эм Даблю Ти Эс ҮЦК” ХХК	“Бумбат-Алтай ҮЦК” ХХК
6	“Превалент ҮЦК” ХХК	“Бумбат-Алтай ҮЦК” ХХК
7	“Зюс капитал ҮЦК” ХХК	“Би Ди Сек ҮЦК” ХК

АУДИТЫН ТАЙЛАН

2007	48	1,733.00	20,796.00	3,445.00	34,557.00	345.00	234,768.00	42,343.00	34,534.00
2007	60	2,315.00	2,315.00	45,534.00	7,566.00	42,456.00	234,234.00	5,564.00	342.00
2011	30	3,200.00	38,484.00	38,484.00	38,484.00	5,345.00	634,567.00	234,676.00	23,442.00
2011	60	1,347.00	16,164.00	16,164.00	16,164.00	16,164.00	10,776.00	234,423.00	46,456.00
2007	60	2,621.00	15,726.00	15,256.00	33,245.00	3,423.00	34,423.00	42,234.00	4,234,467.00
2007	60	2,276.00	2,276.00	25,412.00	54,322.00	2,342.00	345,532.00	345,534.00	34,233.00
2007	60	3,029.00	18,174.00	3,654.00	23,312.00	3,423.00	23,423.00	34,553.00	246,723.00
2009	60	4,610.00	55,320.00	55,320.00	9,220.00	234,423.00	234,233.00	45,344.00	24,423.00
2011	60	2,619.00	31,428.00	31,428.00	31,428.00	31,428.00	534,457.00	45,573.00	3,442,344.00
2011	180	1,231.00	14,772.00	14,772.00	14,772.00	14,772.00	14,772.00	14,772.00	140,334.00
2009	180	1,264.00	15,168.00	15,168.00	15,168.00	15,168.00	15,168.00	15,168.00	114,744.00
2009	180	4,890.00	58,680.00	58,680.00	58,680.00	58,680.00	58,680.00	58,680.00	144,096.00
2007	180	1,142.00	13,704.00	13,704.00	13,704.00	13,704.00	13,704.00	13,704.00	440,100.00
2011	30	1,327.00	15,924.00	15,924.00	15,924.00	15,924.00	15,924.00	15,924.00	391,465.00
2009	60	4,250.00	51,000.00	51,000.00	51,000.00	51,000.00	51,000.00	51,000.00	1,122,000.00
2009	60	3,907.00	46,884.00	46,884.00	46,884.00	46,884.00	46,884.00	46,884.00	1,031,448.00
2009	60	3,156.00	37,872.00	37,872.00	37,872.00	37,872.00	37,872.00	37,872.00	833,184.00
			480,091.00	512,600.00	550,009.00	3,955,090.00	2,000,000.00	1,835,094.00	12,938,520.00



2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17



Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар-14240,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Энэтхэгийн өргөн чөлөө 17
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас: +976 7011 8101
Факс: +976 7011 8102
www.kpmg.com/mn

Хараат Бус Аудиторын Тайлан

Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчид:

Дүгнэлт

Бид Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК (цаашид “Компани” гэх)-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, мөн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй болон тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, компанийн санхүүгийн тайлан нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”)-ын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын Хүлээх Үүрэг Хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НБЁЗОУСЗ”)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу компаниас хараат бус байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах нь компанийн удирдлагын үүрэг хариуцлага юм. Залилан эсвэл алдааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбоотой удирдлагын шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтууд нь мөн энэхүү хариуцлагад хамаарна.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс компанийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайланд тодруулж, компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг компанийн удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нэгдсэн дүнгээрээ уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж болон мэргэжлийн үл итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.



- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх сүүрийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондоо тулгуурлан компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлтээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ хязгаарлах шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь компанийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад илрүүлсэн томоохон асуудлууд, тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.



Кай Пн Эм Жи Аудит ХХК
LLC
Монгол Улс, Улаанбаатар хот
2019 оны 3 дугаар сарын 20-ны өдөр

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгажгүйг анхаарна уу. Энэхүү тайлан нь зөвхөн компанийн хувьцаа эзэмшэгчид зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гурвалдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	<u>2018</u>	<u>2017</u>
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	2,172,002	2,264,092
Биет бус хөрөнгө	<u>1,192,669</u>	<u>1,271,900</u>
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>3,364,671</u>	<u>3,535,992</u>
Эргэлтийн хөрөнгө		
Бараа материал	26,340	16,331
Бусад хөрөнгө оруулалт	1,000	1,000
Урьдчилгаа	16,945	14,480
Дансны авлага	299,461	82,852
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	830,386	1,306,884
Бусад эргэлтийн хөрөнгө	<u>13,160</u>	<u>13,160</u>
Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>1,187,292</u>	<u>1,434,707</u>
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,551,963</u>	<u>4,970,699</u>
ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ		
Эздийн өмч		
Хувьцаат капитал	23,130,594	21,884,000
Бусад нөөц	458,684	1,705,278
Хуримтлагдсан алдагдал	<u>(20,251,939)</u>	<u>(18,992,094)</u>
Эздийн өмчийн дүн	<u>3,337,339</u>	<u>4,597,184</u>
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	1,052,005	325,000
Орлогын албан татварын өглөг	5,451	5,136
Бусад өглөг	156,032	41,324
Урьдчилж орсон орлого	<u>1,136</u>	<u>2,055</u>
Богино хугацаат өр төлбөрийн дүн	<u>1,214,624</u>	<u>373,515</u>
ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	<u>4,551,963</u>	<u>4,970,699</u>

АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2018</u>	<u>2017</u>
Борлуулалтын орлого	1,656,960	1,830,553
Нийт орлого	1,656,960	1,830,553
Ерөнхий ба удирдлагын зардал	(1,290,434)	(1,210,451)
Милленниум Ай Ти системтэй холбоотой тайлант жилийн зардал	(1,273,769)	(908,749)
Авлагын үнэ цэнийн бууралтын зардал	(18,171)	(27,375)
Санхүүгийн орлого	94,606	55,054
Гадаад валютын ханшийн цэвэр олз / (гарз)	(30,306)	15,771
Бусад орлого	<u>37,888</u>	<u>16,956</u>
Тайлант үеийн үйл ажиллагааны алдагдал	(823,226)	(228,241)
Милленниум Ай Ти системтэй холбоотой өмнөх жилийн зардал*	(427,175)	=
Татварын өмнөх алдагдал	<u>(1,250,401)</u>	<u>(228,241)</u>
Орлогын албан татварын зардал	(9,444)	(4,920)
Тайлант үеийн алдагдал	(1,259,845)	(233,161)
Тайлант үеийн нийт дэлгэрэнгүй алдагдал	<u>(1,259,845)</u>	<u>(233,161)</u>

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>Хувьцаат капитал</u>	<u>Бусад нөөц</u>	<u>Хуримтлагдсан алдагдал</u>	<u>Нийт эздийн өмч</u>
2016 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	21,884,000	458,684	(18,758,933)	3,583,751
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	-	(233,161)	(233,161)
Өмчид шууд бүртгэсэн эзэмшигчидтэй хийсэн ажил гүйлгээ				
Хувьцаа эзэмшигчээс оруулсан санхүүжилт		<u>1,246,594</u>	-	<u>1,264,594</u>
2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	21,884,000	1,705,278	(18,992,094)	4,597,184
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	-	(1,259,845)	(1,259,845)
Хувьцаат капитал руу хөрвүүлэлт	<u>1,246,594</u>	<u>(1,246,594)</u>	-	-
2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	<u>23,130,594</u>	<u>458,684</u>	<u>(20,251,939)</u>	<u>3,337,339</u>

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	<u>2018</u>	<u>2017</u>
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Тайлант үеийн алдагдал	(1,259,845)	(233,161)
Тохируулга:		
Элэгдэл ба хорогдол	631,260	620,930
Авлагын үнэ цэнийн бууралтын нөөц	18,171	27,375
Орлогын албан татварын зардал	9,444	4,920
Ханшийн зөрүүний хэрэгжээгүй цэвэр (олз) гарз	34,149	(30,287)
Хүүгийн орлого	<u>(94,606)</u>	<u>(55,054)</u>
Ажлын капиталын өөрчлөлтөөс өмнөх үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(661,427)	334,723
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт:		
Дансны авлага	(234,780)	38,266
Урьдчилгаа	(2,465)	(12,110)
Бараа материал	(10,009)	(3,331)
Дансны болон бусад өглөг	807,205	(847,376)
Урьдчилж орсон орлого	<u>(919)</u>	<u>2,055</u>
	(102,395)	(487,773)
Хүлээн авсан хүүгийн орлого	94,606	55,054
Төлсөн орлогын албан татвар	<u>(9,129)</u>	<u>(918)</u>
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	<u>(16,918)</u>	<u>(433,637)</u>
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(37,266)	(21,889)
Худалдан авсан биет бус хөрөнгө	(422,673)	-
Засгийн Газрын үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт		(194,396)
Засгийн Газрын үнэт цаасны буцаан төлөлт	=	<u>194,396</u>
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	<u>(459,939)</u>	<u>(21,889)</u>
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хувьцаа эзэмшигчээс оруулсан санхүүжилт	=	<u>1,246,594</u>
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	=	<u>1,246,594</u>
Ханшийн өөрчлөлтийн нөлөөлөл	359	674
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)	<u>(476,498)</u>	<u>791,742</u>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,306,884	515,142
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>830,386</u>	<u>1,306,884</u>



Монголын хөрөнгийн бирж
Сүхбаатарын талбай - 3, Улаанбаатар 15160, Монгол Улс
Утас: 11-313747, Факс: 976-11-325170
www.mse.mn
info@mse.mn